



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 5,400,000.00 (таван сая дөрвөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005850
23-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт



"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Мотоцикл /Daun/, улсын дугаар 22-34 AP3, арлын дугаар L7GРСКLY9H1061228	2017.07.25	24489	1,800,000.00	ш	1	1,800,000.00	500,000.00
2	Мотоцикл /Daun/, улсын дугаар 22-35 AP3, арлын дугаар L7GРСКLY1H1055794	2017.07.25	21690	1,800,000.00	ш	1	1,800,000.00	500,000.00
3	Мотоцикл /Daun/, улсын дугаар 22-36 AP3, арлын дугаар L7GРСКLY1H1056038	2017.07.25	22854	1,800,000.00	ш	1	1,800,000.00	500,000.00
				5,400,000.00		3	5,400,000.00	1,500,000.00
Нийт дүн				(таван сая дөрвөн зуун мянга)		(гурав)	(таван сая дөрвөн зуун мянга)	(нэг сая таван зуун мянга)